

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ **/8-р сарын байдлаар/**

I. ТӨСӨВ: 2013 оны 1-р сарын 1-нээс “Төсвийн тухай хууль” шинээр хэрэгжиж эхэлснээр сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, соёлын байгууллагууд, хүүхэд гэр бүлийн хэлтэс, газрын алба, халамж асрамжийн үйлчилгээ зэрэг зардлууд орон нутгийн төсвөөс санхүүжих болсонтой холбоотойгоор төсвийн зардал ихээр нэмэгдэж байна.

Мөн орлогын хувьд орон нутагт төвлөрдөг байсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, лицензийн төлбөр нь улсын төсөвт төвлөрдөг болсон. Дээр нэмэгдэж буй зардлыг санхүүжүүлэх зорилгоор улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгийн орлогыг орон нутгийн төсөвт оруулдаг болсон.

Аймгийн төсвийн орлогод 32.6 тэрбум төгрөг орж, төлөвлөгөөгөө 1.0 хувиар давуулан биелээд байна
Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилт 26.7 тэрбум төгрөгт хүрсэн байна.

II. МӨНГӨ, ЗЭЭЛ: Монгол банкны мэдээгээр ХААН, Хас, Голомт, Төрийн банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 67.1 тэрбум төгрөгт хүрсэн нь оны эхнээс 24.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн үлдэгдэл 26.5 тэрбум төгрөгт хүрч, оны эхнээс 4.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

III. ХӨДӨӨ АЖ АХУЙ: **Хадлан бэлтгэл:** Өвөлжилтийн бэлтгэл ажил сумдад эхлээд байна. Онгон, Түвшинширээ, Халзан, Эрдэнэцагаан сумдаас бусад 9 сум нийтдээ 1.7 мянган тонн өвс, Асгат, Баяндэлгэр, Наран, Баруун-Урт зэрэг сумдад нийтдээ 42.7 тонн гар тэжээлийг бэлтгэсэн гүйцэтгэлтэй байна.

IV. АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 19.1 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 1.4 тэрбум төгрөгөөр буюу 0.9 хувиар доогуур байна.

Оны үнээр 69.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 10.5 тэрбум төгрөгөөр доогуур гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс нарийн боов, тараг, дулаан, тоосго, блок, замын хавтан, яндан, пийшин, шургуулга, түлээний авдар, угаалтуур, тогооны таг, хогийн утгуур, савар, агааржуулагч, галын хайч, хаалт, жигнүүр, сандал, хаалганы үйлдвэрлэлт өнгөрсөн оны мөн үеэс дээгүүр үзүүлэлттэй байна.

Харин дээл, хантааз, талх, ул боов, ганбургер, хиам, зайрмаг, замын хавтан, нүүрс, цайрын баяжмал, бордурын үйлдвэрлэлт өнгөрсөн оны мөн үеэс доогуур үзүүлэлттэй байна

Энэ сард шинээр ариун цэврийн цаасыг Түмэнцогт суманд шинээр үйлдвэрлэж эхлээд байна.

V. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС: Хэрэглээний үнийн индекс 8-р сард өмнөх 2012 оны жилийн эцсийнхээс 5.5 хувиар өслөө.

Энэхүү өсөлтийн цаана хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 7.9 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлгийн үнэ 7.2 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 5.1 хувь, тээврийн бүлгийн үнэ 2.4 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 5.7 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 11.8 хувь, бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ 10.6 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

VI. ЭРҮҮЛ МЭНД: Эхний 8-н сард 833 эх амаржиж, 839 хүүхэд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс доогуур байна.

Халдварт өвчнөөр 755 хүн өвчилсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 307-оор олон байгаа бөгөөд гахай хавдар, тэмбүү, салхинцэцэг, сүрьеэ, заг зэрэг өвчлөлүүд өссөн байна.

VII. АЖИЛГҮЙЧҮҮД: Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 903 болж, өнгөрсөн оны мөн үеэс 1 хувиар өссөн байна. Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 66,1 хувь нь 15-34 насны залуучууд байна. Боловсролын түвшинээр авч үзвэл 17,5 хувь нь дээд, 7,3 хувь нь тусгай дунд, 44 хувь нь бүрэн дунд, 5.5 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

VIII. ГЭМТ ХЭРЭГ: 195 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 35-аар дээгүүр байна. Гэмт хэргийн улмаас 16 хүн нас барж, 82 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 374.6 сая төгрөгийн хохирол учирсны 83.5 хувийг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 182 хүн холбогдон сэжиглэгдсэний 36.8 хувь нь согтуугаар, 19.2 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 1923 хүн эрүүлжигдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 117 хүнээр буурсан байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 404 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.



АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС